



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

**«Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын»
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 68,143,724.0 /жаран найман сая нэг зуун дөчин гурван мянга долоон зуун хорин дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Б.Индра/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 68,143,724.0 /жаран найман сая нэг зуун дөчин гурван мянга долоон зуун хорин дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Б.Индра/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2020 оны 03 дугаар
 сарын 24 өдрийн 198 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Авто замын хөгжлийн газар

| Д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | ӨХБЗ-ийн дүгнэлт | ЭБХХХ комиссын хуралд оруулах санал |
|---|------------------------------|---------------|-------------|------------|-------------------|-------------------|--------------------|--------------|------------------|-------------------------------------|
| Машин тоног төхөөрөмж | | | | | | | | | | |
| 1 | Нягт чийг тодорхойлогч багаж | 2012.04.01 | ш | 1 | 55,595,724 | 55,595,724 | 55,595,724 | - | устгах | устгах |
| 2 | Цөмийн үүсгүүр багаж | 2008.07.01 | ш | 1 | 12,548,000 | 12,548,000 | 12,548,000 | - | устгах | устгах |
| Машин, тоног төхөөрөмжийн дүн | | | | 2 | 68,143,724 | 68,143,724 | 68,143,724 | | | |
| Нийт данснаас хасагдах хөрөнгийн дүн | | | | | | 68,143,724 | | | | |
| Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | 68,143,724 | | | | |